

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: АГГ-2022/16-ШТА-ГА

Хөрөнгө оруулалтыг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөн хэрэгжүүлэх
шаардлагатай байна

Даланзадгад хот 2022 он



Дарга, Тэргүүлэх аудитор С.Цэрэнбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn

Аудитын менежер Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Аудитор Ю.Энхтуяа

Утас: 70533552 Цахим хаяг: Enkhtuyayu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хаяг: www.audit.mn

Аудитыг гүйцэтгэсэн:		Агуулга	Хуудас
Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор	С. Цэрэнбаяр	Товчилсон үгийн тайлбар	2
		Хүснэгт, график, зургийн жагсаалт	2
		Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	3-4
		Ерөнхий мэдээлэл	4-6
Аудитын менежер:	Т.Хонгорзул	А. Төсөл, арга хэмжээг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөөгүй байна.	7-10
Аудитор:	Ю. Энхтуяа Ч.Наранбадрах	1. Хөрөнгө оруулалтыг үр ашигтай төлөвлөөгүй байна. 2. Зарим төсөл, арга хэмжээ төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна	10-16
2022 оны 4 дүгээр сар		Б. Зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70533539, 70533552 дугаарын утсаар харилцана уу.	Тайланг ӨМТАГ-ын www.umnugovi@audit.gov.mn цахим хуудаснаас үзнэ үү.	1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зарим үйл ажиллагаа хууль, журмын хүрээнд зохион байгуулагдаагүй байна.	
		2. Зарим төсөл арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, гүйцэтгэлийн чанарт тавих хяналт сул байна.	
		3. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн зарим төсөл, арга хэмжээ үр дүнгүй байна.	
		4. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчил давтагдсаар байна	
Хаяг: Нутгийн удирдлагын ордон, 3 давхар, 303 тоот		Дүгнэлт	17
		Зөвлөмж	18
		Хавсралт № 1-2 Тэргүүлэх аудиторовн тушаал	19

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БОГ	Байгаль орчны газар
БНБД	Барилгын норм ба дүрэм
БХТ	Барилгын хөгжлийн төв
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМГ	Эрүүл мэндийн газар

Хүснэгт, графикийн жагсаалт

Хүснэгт 1	Дуусаагүй, гэрээ сунгагдсан төсөл, арга хэмжээний судалгаа
Хүснэгт 2	Батлагдсан төсөл арга хэмжээний жагсаалт
График 1	2021 онд хийгдсэн санхүүжилт
График 2	Эрх шилжин хэрэгжсэн ТАХ-ий судалгаа
График 3	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл

Зургийн жагсаалт

Зураг 1,2	Оюутны хотхоны эскиз ба бодит байдал
Зураг 3,4	Булган сумын өвлийн хүлэмжийн байдал
Зураг 5-7	Булган сумын 10 айлын орон сууцны байдал
Зураг 8-13	Театрын барилгын байдал
Зураг 14,15	Ухаалаг дахивар цуглуулагчийн байдал
Зураг 16,17	Угсраагүй тоног төхөөрөмжийн байдал
Зураг 18,19	Булган сумын сургуулийн тоног төхөөрөмж
Зураг 20,21	Хог ангилан ялгах савны байдал

Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол улсын Ерөнхий аудиторов 2022 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалаар баталсан аудитын сэдвийг үндэслэн хийлээ.

Аудитын зорилт:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг Нийслэл дэх Төрийн аудитын газарт хүргүүлэх, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй эсэх
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй эсэх.

Хамрах хүрээ:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний төлөвлөлт хийсэн судалгаа, шинжилгээний баримт материал, ажлын тайлан, төсөл арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд эрх бүхий байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлд үндэслэн аудитыг хийлээ.

Аудитын арга зүй:

Тус аудитаар орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээ хэрэгжүүлсэн Төсвийн ерөнхийлөн захирагч болон харьяа байгууллагууд, сумдын Засаг дарга, төсөл арга хэмжээг гүйцэтгэгч аж ахуйн нэгж, бусад байгууллагын холбогдох үйл ажиллагааг хамруулав.

Аудитыг АДБОУС 3000-3100, Монгол улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ыг баримтлан холбогдох баримт материалд үндэслэж, тулган баталгаажуулах, албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, судалгаа авах, мэдээ, тайланг судалж, нөхцөл байдлын шинжилгээ хийх, хөрөнгө оруулалтыг бодит байдалд очиж зураг авалт, тооллого хийх зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудсын дагуу аудитын дүн, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулав.

Хүндрэл, бэрхшээл

Аудит гүйцэтгэх хугацаа бага, бүх хийгдсэн хөрөнгө оруулалтыг газар дээр нь очиж шалгах хүний нөөц дутагдалтай, албан томилолт, шатахууны зардал хүрэлцэхгүй байлаа.


Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн

Аудитыг Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор С.Цэрэнбаяр хянан удирдаж, аудитын менежер Т.Хонгорзул үе шатны хяналтыг хэрэгжүүлж, аудитын аудитор Ю.Энхтуяа, Ч.Наранбадрах нар гүйцэтгэв.

Ерөнхий мэдээлэл

Тайлант онд хэрэгжсэн нийт ТАХ-ий санхүүжилтийн 75,9 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт эзэлж байна. Нийт санхүүжилтийг батлагдсан төсөвтэй харьцуулахад 84.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

График № 1. 2021 онд хийгдсэн санхүүжилт



Нийт хөрөнгө оруулалтаас 2021 онд санхүүжих, 23,676.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 25 ТАХ дунджаар 59.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Гэрээ сунгалтын шалтгаан нь цар тахлын нөхцөл байдал, импортын барааны татан авалтаас ихэвчлэн шалтгаалсан байна. Цаг хугацаа ажиллах хүчний нөхцөл байдлаас шалтгаалан, нийт хэрэгжүүлсэн ТАХ-ээс түүврийн байдлаар сонгон, аудитыг гүйцэтгэлээ. Энэ оны сүүлийн хагас жилд хийгдэх “Орон нутгийн хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн эсэх, чанар, үр дүн, үр нөлөө (2016-2021 он)” гүйцэтгэлийн аудитаар үлдсэн ТАХ-г хамруулахаар төлөвлөөд байна.

Хүснэгт № 1. Дуусаагүй, гэрээ сунгагдсан төсөл, арга хэмжээний судалгаа

	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих дүн	Ажлын гүйцэтгэл		
		Эхлэх	Дуусах			Ажил эхэлснээс хойших гүйцэтгэл, мөнгөн дүн /сая төг/	Тайлант үеийн гүйцэтгэл, мөнгөн дүн /сая төг/	Хувь
1	Хөгжимт жүжгийн театрын тайзны засал, шаардагдах тоног төхөөрөмжийн угсралт нийлүүлэлт	2021	2021	158.1	158.1	120.1	120.1	76

2	ХЖТ-ын тайзны засал, шаардлагатай тоног төхөөрөмжийн угсралт нийлүүлэлтийн ажил	2019	2021	1,585.2	317.0	1,505.9	228.6	95
3	Даланзадгад сумын 5 дугаар багийн шинээр баригдсан барилгын гадна, дотор тохижилт, тоног төхөөрөмж нийлүүлэх	2021	2021	48.2	48.2	24.1	24.1	50
4	Хүрмэн сумын 320 хүүхдийн сургуулийн барилга барих	2020	2022	3,292.2	2,292.2	2,400.0	1,400.0	73
5	Өмнөговь аймгийн хөгжлийн хөтөлбөр 2030	2021	2022	99.3	99.3	29.0	29.0	29
6	Даланзадгад сумын Өнө-Орших өрхийн эмнэлгийн барилгын зураг төсөл, төсөв боловсруулах	2021	2022	28.0	28.0	22.4	22.4	80
7	Төрийн архивын байрны барилгын зураг, төсөв	2021	2022	35.6	35.6	28.5	28.5	80
8	Мандал-Овоо сумын соёлын төвийн барилгыг барих	2020	2022	2320.0	1,820.0	2,081.8	1,581.8	90
9	4 дүгээр орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулах ажил Багц-1	2021	2022	998.0	998.0	399.2	399.2	40
10	4 дүгээр орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулах ажил Багц-2	2021	2022	998.0	998.0	99.8	99.8	10
11	Даланзадгад сумын Нанзад хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах	2020	2022	992.2	396.9	793.7	198.4	80
12	Сэврэй суманд хагас автомат уурын зуух, дулааны шугамыг барих	2021	2022	2073.5	1,500.0	1,500.0	1,500.0	72
13	Баяндалай сумын сургуулийг тоног төхөөрөмжөөр хангах	2021	2022	69.8	69.8	30.9	30.9	44
14	Цогт-Овоо сумын 320 хүүхдийн сургуулийн барилга	2021	2022	636.8	636.8	573.1	573.1	90
15	Ханбогд сумын орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээг барьж байгуулах ажил	2020	2021	1,387.9	254.1	1,253.2	215.7	90
16	Хүрмэн Баяндалай чиглэлийн 10кв-ын шугамын тулгуур шонг шинэчлэх /40км/	2021	2022	476.4	476.4	238.2	238.2	50
17	Даланзадгад сумын төвийн гэр хороололд цэвэр бохир усны шугам сүлжээг өргөтгөж, ус түгээх байр барих	2021	2022	1,669.9	1,669.9	668.0	668.0	40
18	Сумдад үүрэн холбооны тархалтыг нэмэгдүүлэх /Ханхонгор сум/	2021	2022	140.0	140.0	112.0	112.0	80
19	Даланзадгад сумын хэрэглэгчдийг хэрэглээний халуун устай болгох засвар үйлчилгээг хийх	2021	2021	406.5	406.5	203.2	203.2	50
20	Сэврэй суманд 320 хүүхдийн сургууль барих	2021	2022	4,260.0	1,000.0	1,000.0	1,000.0	23

21	Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Баяндалай, Ноён, Сэврэй, Хүрмэн сумдын нутаг дэвсгэрт инженерийн хийцтэй 12 худаг шинээр гаргах	2021	2021	280.0	280.0	224.0	224.0	80
22	Агаарын бохирдолгүй Өмнөговь хөтөлбөрийг хэрэгжүүлж шинэ технологи, цахилгаан халаагуур, тарифт тоолуур хэрэглээг нэмэгдүүлэх багц-2	2021	2021	458.9	458.9	229.4	229.4	50
23	Шинэ технологи, цахилгаан халаагуур, тарифт тоолуур хэрэглээг нэмэгдүүлэх Багц-1	2021	2021	377.3	377.3	301.8	301.8	80
24	Хонгорын гол, Хэрмэн цав орчмын байгалийн үзэсгэлэнт газрын менежментийн төлөвлөгөөний дагуу тохижилтын ажлыг үргэлжлүүлэх, нарны сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт холбох багц-1	2021	2021	179.0	179.0	107.4	107.4	60
25	Шар цав, хүрдэт агуйн соёлын өвийг аялал жуулчлалтай хослуулан хамгаалах ажил түлхүүр гардуулах нөхцөл	2020	2021	705.6	141.1	141.1	141.1	20
НИЙТ ДҮН				23,676.4	14,781.1	14,087.1	9,677.0	59.5

Аймгийн Засаг даргын 2021 оны А/312 дугаар захирамжаар 4,124.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 ТАХ-г 8 суманд эрх шилжүүлэн гүйцэтгүүлсэн байна.

График № 2. Эрх шилжин хэрэгжсэн ТАХ-ий судалгаа



Талбарын ажлаар Даланзадгад, Булган, Ханхонгор, Цогт-Овоо сумдад ажилласан.

А. Төсөл, арга хэмжээг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөөгүй байна.

1. Хөрөнгө оруулалтыг үр ашигтай төлөвлөөгүй байна.

1.1 Аймгийн Засаг даргын 2020 оны 1-2593 дугаар албан бичгээр сумдын ЗДТГ-ын дарга нарт “Аймгийн хөгжлийн 2021 оны жилийн төлөвлөгөөний төсөлд санал бэлтгэн ирүүлэх, тухайн ТАХ нь Төсвийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагуудыг хангасан байх тухай” чиглэл өгч, санал авах маягтыг хавсралтаар хүргүүлсэн байна.

1.2 Аймгийн ИТХ-ын төлөөлөгч бүр өөрийн тойрогт хэрэгжүүлэх ТАХ-ий саналаа 2020 оны 11 дүгээр сард багтаан аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна.

1.3 Орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй дараах 18 төсөл, арга хэмжээг төлөвлөж, 1,959.6 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна. Үүнд:

- Шүүх хурал хийхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах-25.0 сая төгрөг,
- Шүүхийн шинжилгээний албыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах-27.0 сая төгрөг,
- Зэвсэгт хүчний 148 дугаар тусгай ротын гадна хашаа, зам талбайг засварлахад 21.0 сая төгрөг,
- Хилийн цэргийн 0166-р ангийн харилцаа холбоог өндөр хүчин чадал бүхий холбооны хэрэгслээр хангахад 50.0 сая төгрөг,
- Хилийн цэргийн 0131 дүгээр ангийн ажилчдын байрыг шинээр барих ажлын зураг төсөл боловсруулахад 46.9 сая төгрөг,
- Хилийн цэргийн 0131 дүгээр ангийн ажилчдын байрыг шинээр барих-250.0 сая төгрөг,
- Ханбогд сум дахь ШШГХ-ийг автомашинаар хангахад 35.0 сая төгрөг,
- Шивээ хүрэн автозамын боомт хариуцсан хэсгийг дохиолол хяналт хамгаалалтын нэгдсэн системээр төхөөрөмжлөхөд 70.0 сая төгрөг,
- Хилийн цэргийн 0131, 0166 дугаар ангийн хилийн харуулуудын уналгад ашиглах мотоциклийг нийлүүлэхэд 50.0 сая төгрөг,
- Үндэсний аюулгүй байдлыг хангах, албан үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдах автомашин, шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангахад 86.0 сая төгрөг,
- Гадаадын иргэн, харьяатын газрын албаны байрны тоног төхөөрөмж нийлүүлэхэд 143.4 сая төгрөг,
- Прокурорын газрын эрүүгийн хэргийн салбар архив, байгууллагын архив, эд мөрийн баримт хадгалах өрөөг стандартын дагуу тохижуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангахад 30.0 сая төгрөг,
- Хилийн цэргийн 0131 дүгээр анги, Цагдаагийн газрын автомашины эвдрэл гэмтлийг засварлахад 5.1 сая төгрөг,
- Дотоодын цэргийн 0167-р ангийн дулаан цэвэр усны шугам сүлжээг өргөтгөж, гадна шугам сүлжээг барихад 778.2 сая төгрөг,
- Хилийн цэргийн 0153 дугаар салбар "Шүүлэн булаг"-ын байрны их засварлахад 102.0 сая төгрөг,

- Хилийн цэргийн 0166 дугаар ангийг туулах чадвар сайтай автомашинаар хангахад 150.0 сая төгрөг,
- Хилийн цэргийн 0154 дүгээр салбарын цэргийн байрны халаалтын шугамыг шинэчлэн засварлахад 45.0 сая төгрөг,
- Хилийн цэргийн 0154 дүгээр салбарын ажилчдын барилгын дулааны шугамыг шинэчлэхэд 45.0 сая төгрөг төлөвлөсөн байна.

1.4 Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.2 ¹-дэх заалттай нийцэхгүй байна.

1.5 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хэлэлцэхдээ эрэмбэлэх, олон нийтийн санал авах үйл ажиллагаа явуулдаггүй байна.

1.6 Байгууллага болон ИТХ-ын төлөөлөгч нарын ирүүлсэн саналыг ХОХБТХ-ийн мэргэжилтэн хариуцан жагсааж, Засаг даргын зөвлөл, ИТХ-ын намын бүлэг, Тэргүүлэгчдээр хэлэлцүүлж, саналыг тусган аймгийн ИТХ-ын хуралдаанд оруулдаг байна.

1.7 Энэ нь нэн тэргүүний ач холбогдолтой байхаас илүүтэй ИТХ-д олонх болсон намын бүлэг, төлөөлөгчдийн ирүүлсэн санал дэмжигдэх магадлалтай байна.

1.8 Төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй бус, иргэдийн хэрэгцээ шаардлагад үндэслээгүй байна. Үүнд:

- Олон нийттэй харилцах албыг тоног төхөөрөмжөөр хангах (багц-1) ажилд нийт 47.7 сая төгрөгийн 19 нэр төрлийн 36 ширхэг тоног төхөөрөмж нийлүүлсний дотор 8.9 сая төгрөгийн 2 ширхэг iphone pro max гар утас багтсан,
- Барилгын материалын лабораторийг тоног төхөөрөмжөөр хангах ажлын тендерийн хэмнэлтээс 34.8 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулж, тус бүр нь 3.4 сая төгрөгийн 4 ширхэг суурин компьютер, 6.5 сая төгрөгийн 1 ширхэг зөөврийн компьютер, 4.2 сая төгрөгийн 1 ширхэг ipad pro, 7.6 сая төгрөгийн лабораторийн багаж 2 ширхэг худалдан авсан байна.

2. Зарим төсөл, арга хэмжээ төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна

2.1 Сангийн сайдын 2019 оны 219 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 7 “Төсөл арга хэмжээнд тавигдах шаардлага”-д заасныг хангаагүй төсөл, арга хэмжээг баталсан байна. Үүнд:

- Хилийн цэргийн 0131 дүгээр ангийн ажилчдын байрыг шинээр барих ажил (250.0 сая төгрөг) зураг төсөвгүй, газар олголт хийгдээгүй байсан,
- Даланзадгад сумын 3 дугаар сургуулийн хүүхдийн хоолны газрын барилга барих ажил (480.0 сая төгрөг)-ын зураг, төсвийн ажил удааширснаас барилга угсралтын ажил эхлээгүй,

¹ төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх

2.2 Аймгийн ИТХ-ын 2021 оны 3/2 дугаар “2021 оны төсвийн тодотгол батлах тухай” тогтоолоор аймгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын зардлын ажлыг тодотгон баталсан байна.

Хүснэгт № 2. Батлагдсан төсөл арга хэмжээний жагсаалт

(төгрөг)

Төсөл, арга хэмжээ	2020.12.03 ИТХ-ын тогтоол № 2/8		2021.08.25 ИТХ-ын тогтоол №3/2 (тодотгол)	
	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ	62	50,136,600	91	50,085,400
Орон нутгийн төсвийн байгаль хамгаалах чиглэлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ	16	6,757,900	17	6,944,000
Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөтөлбөр төсөл, арга хэмжээ	48	13,355,100	47	12,619,300
Замын сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт	3	5,000,000	3	6,011,331
Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ	11	9,747,400	11	12,973,427
Нийт дүн	140	84,997,000	169	8,633,458

Эх сурвалж: Аймгийн ИТХ-н тогтоол

2.3 Зарим төсөл, арга хэмжээг санхүүжилтийн эх үүсвэргүй баталснаас хугацаандаа хэрэгжээгүй байна.

2.4 Аймгийн оюутнуудын сурах, амьдрах орчныг сайжруулах зорилгоор “Оюутны хотхон”-ы барилгыг барьж ашиглалтад оруулж, ашиглалтын менежментийг бий болгох ажлыг 2,000.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан боловч санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдээгүйгээс хэрэгжээгүй байна.

2.5 Уг барилга нь Улаанбаатар хотод 2019 оноос эхлэн баригдаж байгаа бөгөөд 500 оюутны хүчин чадалтай, 70 хувьтай гүйцэтгэлтэй байна.

Зураг № 1,2. Оюутны хотхоны эскиз ба бодит байдал



2.6 Нутгийн үйлдвэрлэгч хөтөлбөр хэрэгжүүлж, аймгийн бизнес эрхлэгч аж ахуйн нэгжийг өрсөлдөх чадвартай болгох бодлого хэрэгжүүлэх ажлыг 2,000.0 сая төгрөгөөр

санхүүжүүлэхээр тусгасан боловч 20.0 сая төгрөгийн өртөгтэй 5 ширхэг арьс нэхий боловсруулах үйлдвэр байгуулсан хэрэгжилттэй байна.

2.7 Цогтцэций сумын шинэ суурьшлын бүсийн инженерийн дэд бүтцийн ажлыг 3,716.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр баталсан боловч санхүүжилтийн эх үүсвэргүйгээс хэрэгжээгүй байна.

2.8 Орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулалтын бус шинж чанартай 263.2 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна. Үүнд:

- Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд орон нутгаас холбогдох байгууллагуудыг оролцуулахад 9.0 сая төгрөг,
- Төсөв санхүүгийн нэгдсэн цахим систем нэвтрүүлж төсвийн урсгал болон хөрөнгийн зардлын санхүүжилт, тайлагналт, хяналтыг сайжруулж, хэмнэлтийн горимд шилжүүлэхэд 5.0 сая төгрөг,
- Говийн гайхамшиг уулзалт зөвлөгөөн зохион байгуулахад 22.5 сая төгрөг,
- Сумдын төвийн хүн амын ундны ус, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөг сайжруулах сургалт зохион байгуулахад 7.5 сая төгрөг,
- Өмнөговь аймгийн төв болон сум, суурин газрын ундны усны чанарын судалгаа, мэдээллийн сан байгуулах, технологийн шийдэл сонгоход 14.3 сая төгрөг,
- Даланзадгад сумын шинэ цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулж, хэвийн үйл ажиллагааг хангах хүрээнд инженер, техникийн ажилчдын цалин урсгал зардалд-200.0 сая төгрөг,
- “Хямд амар” аялал жуулчлалын цахим үзэсгэлэнд оролцоход 4.9 сая төгрөг

2.9 Энэ нь Төсвийн тухай хуулийн 4.1.24² -дэх заалттай нийцэхгүй байна.

2.10 Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтын бус шинж чанартай төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүллээ.

Б. Зарим төсөл арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.

1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зарим үйл ажиллагаа хууль, журмын хүрээнд зохион байгуулагдаагүй байна.

1.1 Төсөл, арга хэмжээг эрх шилжүүлэн гүйцэтгүүлэх шийдвэрийг хуулийн хугацаанд гаргаагүй байна.

1.2. Аймгийн Засаг даргын 2021 оны А/132 дугаар захирамжийн хавсралтаар 2021 онд эрх шилжүүлэн гүйцэтгүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталсан байна.


² хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг

1.3. Энэ нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.2³ “ дэх заалттай нийцэхгүй байна.

1.4. Аймгийн ТЭЗ-ийн ХАА-ны төлөвлөгөөг 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдөр баталж, 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр шилэн дансанд мэдээлсэн байна. Төлөвлөгөөнд 181 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар тусгасан байна.

1.5. ХААА-ы жилийн эцсийн тайлангаас үзэхэд худалдан авах ажиллагааг төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдаагүй байна.

График № 3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл



1.6. Ханхонгор сумын ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин худалдан авахдаа үнэлгээний хороо нь ажлын даалгавраас зөрүүтэй санал ирүүлсэн оролцогчийг шалгаруулсан байна.

1.10. Өмнөговь аймгийн хэмжээнд нийт 95,975.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, тухайн онд 91,123.8 сая төгрөгөөр санхүүжих 306 худалдан авах ажиллагааг зарлаж, 85,022.2 сая төгрөгийн гэрээг байгуулсан ба худалдан авах ажиллагааны тайланг хугацаанд нь хүргүүлсэн байна.

³ Төсвийн Ерөнхийлөн захирагч нь эрх шилжүүлэх тохиолдолд шийдвэрийг тухайн жилийн 2 дугаар сарын 1-ий дотор гаргаж, ажлын 3-5 хоногт Сангийн яаманд хүргүүлнэ”

2. Зарим төсөл арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, гүйцэтгэлийн чанарт тавих хяналт сул байна.

2.1. Зарим гүйцэтгэгч барилга угсралтын ажил гүйцэтгэхдээ БНБД-ийг мөрдөж ажиллаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна. Үүнд:


- Булган сумын өвлийн хүлэмж барих ажлын гүйцэтгэгч дотор ханын засал, агуулахын өрөөнд агааржуулагч хийгээгүй байна.

Зураг № 3,4. Булган сумын өвлийн хүлэмжийн байдал



- Булган суманд баригдсан 10 айлын орон сууцны 2,7 тоот байрны дээврээс цасны ус нэвчсэн, 10 тоот байрны цонхны доогуур цан цохидог, 5 тоот байрны цахилгааны зарим залгуур ажиллахгүй, 4 тоот байрны тагтны хаалгаар шороо орсон байдалтай байна.

Зураг № 5-7. Булган сумын 10 айлын орон сууцны байдал



- Хөгжимт жүжгийн театрын барилгын ажлыг 2021 оны 12 дугаар сард байнгын ашиглалтад улсын комисс хүлээн авсан ч хурлын заал, душ, ариун цэврийн өрөөний ажил дуусаагүй, шатны хашлага хийгээгүй, тайзны дээрээс болон шилэн дээвэр, цонхоор цасны ус нэвтэрч гоожсон, галын крант ажиллахгүй, аваарын дизель генераторын холболт, хашаа хийгээгүй, үзвэрийн заалны тааз эвдэрсэн зэрэг нийт 65 зөрчил байна.

Зураг № 8-13. Театрын барилгын байдал



2.2. “Хөгжил хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ нь 2021 онд 15,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 50 ТАХ-ий хэрэгжилтэд захиалагчийн хяналт гүйцэтгэж, 144.6 сая төгрөгийн захиалагчийн хяналтын зардлаар санхүүжсэн байна.

2.3. Гэвч Төсвийн ерөнхийлөн захирагч “Хөгжил хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын захиралтай байгуулсан гэрээнд барилга, байгууламжийн ажилд захиалагчийн хяналт гүйцэтгэх талаар тусагдаагүй байна.

2.4. Ханхонгор сумын эмнэлгийн барилгын засварын ажил гүйцэтгэх гэрээнд захиалагчийн хяналтыг Нийгмийн бодлогын хэлтэс хэрэгжүүлэхээр тусгасан байна.

2.5. Дээрх тохиолдлууд нь Монгол улсын Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан Барилга захиалагчийн дүрмийн 2.8⁴ - д заасантай нийцэхгүй байна.

2.9. Сумдад эрх шилжин хэрэгжсэн зарим төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт гүйцэтгээгүй байна. Үүнд:

⁴ Захиалагч Барилгын тухай хуулийн 37.1.4-т заасан барилгын үе шатны ажилд тавих хяналтыг хэрэгжүүлэхдээ захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдийг томилон ажиллуулна”

- Ханхонгор суманд хэрэгжсэн “Хөдөөгийн багийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, багийн төвийн барилга шинээр барих” 169.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын захиалагчийн хяналтыг сумын ЗДТГ-ын мэргэжилтэн, нярав, нягтлан нар гүйцэтгэсэн,
- Цогт-Овоо сумын Соёлын төвийн засварын 187.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд захиалагчийн хяналт гүйцэтгээгүй байна.

2.8. Барилга байгууламжийн ажлуудад зохиогчийн хяналтын гэрээг байгуулж, гүйцэтгэл бүрд тайлан, ашиглалтад хүлээн авахад “Зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт” гаргаж баримт бичигт хавсаргасан байна.

2.9. Барилга угсралтын ажлын явцад зохиогч болон захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагаас үүрэг даалгавар өгч, зөрчлийг арилгуулах талаар ажиллаж байгаа боловч ашиглалтад хүлээн авах комисс ажиллахад зөрчил арилаагүй байх, барилга байгууламжийн зүгшрүүлэлтийн хугацаанд материал болон гүйцэтгэлийн чанараас шалтгаалсан доголдлууд гарч байна.

3. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн зарим төсөл, арга хэмжээ үр дүнгүй байна.

3.1 Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний ашиглалын байдлыг шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Гэр хорооллын айл өрхөд зориулалтын хог хаягдлыг ангилан ялгах нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд нийлүүлсэн тоног төхөөрөмжийг бүрэн ашиглаж эхлээгүй байна.

Зураг № 14,15. Ухаалаг дахивар цуглуулагчийн байдал



- Булган сумын сургуулийг тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд нийлүүлсэн тоног төхөөрөмжийг бүрэн угсраагүй, туршиж шалгаагүй байна.

Зураг № 16,17. Угсраагүй тоног төхөөрөмжийн байдал



- Барилгын материалын лабораторийг тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд нийлүүлэгдэх 28.3 сая төгрөгийн 11 нэр төрлийн тоног төхөөрөмж ирээгүй байна.

3.2. Хүлээн авсан зарим тоног төхөөрөмжийг бүрэн хүчин чадлаар нь ашиглахгүй байна. Үүнд:

- Булган сумын сургуулийг тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд нийлүүлэгдсэн ус буцалгах зориулалттай тогоог 1-р хоолны тогооны оронд нийлүүлсэн, цайны газрын цахилгаан нь 380в-д холбогдоогүй учир 2-р хоолны тогоо, төмс арилгагч, ус буцалгагч, махны машиныг ашиглаж эхлээгүй, уур сорогчийг угсраагүй байна.

Зураг № 18,19. Булган сумын сургуулийн тоног төхөөрөмж



- Гэр хорооллын айл өрхөд зориулалтын хог хаягдлыг ангилан ялгах нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд 233.7 сая төгрөгийн өртөгтэй 100 ширхэг хог ангилан хаях савыг гэр хорооллын айлуудад байршуулсан боловч зориулалтаар нь ашиглахгүй, 54.6 сая төгрөгийн өртөгтэй 2 ширхэг шил, лааз хүлээж авах тоног төхөөрөмжийг ажиллуулж туршаагүй, ашиглаагүй, ялган ангилах 20 ширхэг хогийн савнаас 3 ширхэг эвдэрсэн байна.

Зураг № 20,21. Хог ангилан ялгах савны байдал



- Ёл кино театрт шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын хүрээнд 12 төрлийн тоног төхөөрөмж нийлүүлснээс театрын суудлын бүртгэлийн программыг ашиглаж чадаагүй байна.

Цаашид орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ашиглалтын байдлыг сайжруулах, хэрэгцээ шаардлагад нийцсэн төсөл арга хэмжээг төлөвлөн, санхүүжүүлж байх шаардлагатай байна.

4. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчил давтагдсаар байна

4.1 Өмнөх аудитаар илэрсэн 1,177.1 сая төгрөгийн 7 зөрчилд холбогдох хууль, журмын дагуу зөрчил арилгуулах, давтан гарахгүй байх албан шаардлагыг Аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын дарга нарт хүргүүлсэн байна.

4.2 Хүлээн авсан бараа, ажил үйлчилгээ нь техникийн тодорхойлолтоос зөрүүтэй нийлүүлэгдсэн, ашиглалтын явцад гарсан зөрчлийг арилгадаггүй, хөрөнгө оруулалтын ашиглалт хамгаалалт хангалтгүй зэрэг зөрчил давтагдан гарсаар байна.

4.3 Цаашид Төрийн аудитын газраас өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж, төсвийн хөрөнгө оруулалтыг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөн зарцуулахад бүх шатны байгууллагууд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Аудитын дүгнэлт

- Хөрөнгө оруулалтыг үр ашигтай төлөвлөөгүй байна.
- Зарим төсөл, арга хэмжээ төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна
- Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зарим үйл ажиллагаа хууль, журмын хүрээнд зохион байгуулагдаагүй байна.
- Зарим төсөл арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, захиалагч талаас хөрөнгө оруулалтын чанарт тавих хяналт сул байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн зарим төсөл, арга хэмжээ үр дүнгүй байна.
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчил давтагдсаар байна

Аудитын зөвлөмж

Аймгийн Засаг даргад:

- Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулан, илэрсэн алдаа зөрчлийн цаг алдалгүй арилгахад анхаарч ажиллах,
- Тендерийн хэмнэлтээс үүссэн хөрөнгийг Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.3 дахь заалтад нийцээгүй нэмэлт гэрээ байгуулахгүй байх,
- Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2022 оны 4 сарын 27 өдөр

Дугаар А/10

Даланзадгад

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 8.1, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газар, Өмнөговь аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.
3. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, аудитын тайланг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг аудитор (Ю.Энхтуяа)-д үүрэг болгосугай.


С.ЦЭРЭНБАЯР

D:\Бичиг Хэрэг\А Тушаал 2022\А-10.Досх

016010044